



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/207

Алтай хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 78 дугаар тогтоол, 2020 оны 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

2. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн 7.5.1 дэх заалтын зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн багш нарыг чадавхжуулах, байр, сургуулийн орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээний батлагдсан зардлаас Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн дотоод тохижилтын зардалд шаардагдах 34,796,500 (гучин дөрвөн сая долоон зуун ерөн зургаан мянга таван зуу) төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэх эрхийг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг)-д шилжүүлсүгэй.

3. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР